



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/282

Хэрлэн сум

Захирамж хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэр нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Жаргалтхаан сумын иргэн Ж.Цогтбаатар (СМ76122719)-ын эзэмшлийн өвөлжөөний зориулалттай газрын эзэмших эрхийг тус сумын Засаг даргын А/39 тоот захирамжаар хүчингүй болгосон нь Захиргааны ерөнхий хуулийн 26, 27 дугаар зүйлийг зөрчсөн байх тул Жаргалтхаан сумын Засаг даргын 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн А/39 тоот захирамжийг хүчингүй болгосугай.

2.Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Дарханбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ